БАЙГАЛЬТАЙ ЗОХИЦСОН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

# ЭКОЛОГИЙН ДААЦ

ECOLOGICAL CAPACITY

JASIL

2021оны №01

## IFAD-CAPA-SAPA COOPERATION

On the 1st of April 2020, the Secretariat of the International Land Coalition (ILC) and the Rangeland Initiatives in Asia with the support of the Land Tenure Desk requested a meeting with the IFAD APR Regional Economist and PMI Specialists to introduce the new ILC Strategies of rangelands and pastoralists for Central and South Asia; share insights on IFAD's activities on Livestock and Rangelands management, and eventually to discuss potential opportunities for collaboration in the region.

**The agenda went as follow:**

1. Welcome, Introduction & Opening Remarks from IFAD (Jimmy G./Harold L.)
2. Rangelands Initiative Central Asia Platform's & strategy presentation (Hijaba Ykhanbai)
3. Rangelands Initiative South Asia Platform's & strategy presentation (Anu Verma);
4. Questions & Open contribution (all participants);
5. Wrap up & Conclusion by ILC (Jimmy G./Annalisa M.)

**Summary of the main points of discussion:**

After a brief presentation of the two strategies, participants were invited to share insights and ask questions. Several points were mentioned during the conversation, among others we can mention:

Thematic focus:

1. **Access to Credit / Finance:** essential topic to build collaboration with IFAD programmatic operations;
2. **Access to Services / Market:** link the producers to the value-chain and the market, interest to work on community's fibers production in central Asia.
3. **Data Generation:** need to be further developed to allow evidence-based policy dialogue;
4. **Pastoralist Network:** Need to strengthen pastoralist group for increased visibility and strong advocacy capacities;
5. **Tenure Systems & Security:** There is a need to raise awareness on the necessity to strengthen Land Tenure security in IFAD Operation;
6. **Innovation / GIS Technology:** Of interest and represent strong opportunities for collaboration.

**Conclusion and next steps:**

As a result and before concluding, the participant agreed on with the following actions:

1. Share the minutes of the call; the strategies & action plans and the presentations;
2. Develop & Agree on an Roadmap to continue the dialogue with IFAD decentralised offices with the objective to strengthen collaboration;
3. Follow up conversation with the CPMs to identify projects on going or in pipeline that could benefit from additional supports / interventions on land;
4. To share tools, guidelines, and information on past experiences and good practices on land;
5. Explore the possibility to organise Knowledge Events in the regional hubs;
6. To follow up on the abovementioned funding opportunities;

**Annexes:**

1. **CAPA Strategy & Action Plan**
2. **CAPA Presentation:** https://prezi.com/aetkenvtxyc4/capa/
3. **SAPA Strategy & Action Pan**
4. **SAPA Presentation:**
5. **Potential linkages with IFAD portfolio in APR:**
   - **Afghanistan:** The Rural Microfinance and Livestock Support Programme (RMLSP); the Community Livestock and Agriculture Project (CLAP);
   - **India:** Transformation of smallholder farming systems through Crop-Livestock Value chains;
   - **Mongolia:** Project for Market and Pasture Management Development (PMPMD); Project for Market and Pasture Management Development Additional Financing (PMPMD-AF);
   - **Bhutan:** Commercial Agriculture and Resilient Livelihoods Enhancement Programme;
   - **Afghanistan:** Community Livestock and Agriculture Project.
6. **Potential linkages with IFAD portfolio in NEN:**
   - **Kyrgyzstan:** Livestock and Market Development Programme II;
   - **Tajikistan:** Livestock and Pasture Development Project II;
   - **Azerbaijan:** Livestock Productivity and Marketing Improvement Project;
   - **Uzbekistan:** Agriculture Diversification and Modernization Project

## PARTNERSHIPS TO IMPROVE LAND GOVERNANCE

**NES Mongolia: empowering marginalized groups through dissemination of inclusive land governance practices** Securing land rights is the key to end poverty and to build peaceful and just societies. However, land governance is complex and deeply rooted in unequal power relations. To those working to secure land rights, it is clear that this cannot be done in isolation. That is why the International Land Coalition (ILC) has been building and strengthening partnerships based on trust to solve land governance challenges.

National Engagement Strategies - "NES" – are multi-stakeholder platforms led by national actors that help simplify and unpack land governance complexities, using ILC's 10 commitments to people-centred land governance as their compass, while promoting the Voluntary Guidelines on Tenure (VGGT).

Based on collaboration and evidence-based policy dialogue, NES platforms set priorities and design legitimate solutions to the most challenging land related issues in a country. NES platforms include ILC members and non-members and aim at bridging the gap between national and local government, international agencies, and civil society, providing a space to share knowledge and complement each other to improve land governance.

NES Mongolia is interested in exploring together how the EU delegation can engage in this partnership between civil society and government to complement and link our efforts to reach the Sustainable Development Goals by securing land rights.

**Major land governance challenges in Mongolia** Land ownership certificates are relatively new in Mongolia, where private possession of land was introduced only in 2003. Land disputes are frequent in the country and are mostly due to land rights granted in duplication by different government authorities. Although the current system of land related disputes resolution is relatively clear, equal access and fair treatment for all is not yet ensured.

Unsustainable pastureland practices are widespread and lead to degradation due to animal pressures beyond vegetation recovery and absence of seasonal rotations. The current common use regime encourages chaotic use of pastures in which a few wealthy herders, the city rich and companies expand their grazing rights at the expense of other herders' grazing rights, thus increasing social inequality. The direct impact of pasture degradation is declined forage supply, increased malnutrition and exposure to risks, decreased quality and productivity of animals leading to increased income and asset losses of herders.

In 2019, NES Mongolia piloted LANDex, the global land governance index, to monitor land governance and track progress on land-related indicators in the Sustainable Development Goals (SDGs). Government officials are interested in using LANDex as a tool for data collection.

The **overarching objective** of NES Mongolia is to secure land rights for marginalized and vulnerable communities including herders, low income urban ger area inhabitants, ethnic minorities, and women by

1. creating an enabling policy and social environment to formulate and implement pro-people land and development policies and programmes
2. taking effective action against land grabbing by educating stakeholders and non-marginalized communities in traditional land use rights and local livelihoods

**The priorities for NES Mongolia until 2021 are to:**

- establish a strong platform towards people-centered and VGGT-oriented land governance, increasing NES membership and outreach
- work towards the empowerment of primary stakeholders to access and utilize knowledge and good practices for improved governance of land resources for the interest and benefit of communities as a whole
- develop advocacy campaigns for the implementation of inclusive, equitable and gender-sensitive land legislations and land governance practices

support for the approval of Mongolian Proposal for International Year of Rangelands and Pastoralists, IYRP

ILC Members involved: Center for Policy Research (CPR), Jasil Environment and Development Association (JASIL), Mongolian Land Management Association (MLMA) and National Federation of Pasture User Groups (NFPUG)

Other actors involved: Food and Agriculture Organization (FAO), Ministry of Food, Agriculture and Light Industry (MOFALI), Agency of Land Affairs, Geodesy and Cartography (ALAGAC), Ministry of Environment and Tourism Development (METD), National Statistical Office (NSO), People Centered Conservation (PCC).

Facilitator: Dr. B. Erdenebaatar, NES Mongolia (erdene@cpr.mn)

https://www.landcoalition.org/en/explore/our-work/multi-stakeholder-platforms/national-engagement-strategies/mongolia/

JASIL | NES Mongolia | INTERNATIONAL LAND COALITION | UNITED FOR LAND RIGHTS | CAPA | IYRP

## "МОНГОЛ УЛСАД ГАЗАР АШИГЛАЛТЫН ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО"

### сэдэвт цахим хурлын тэмдэглэл

"Газрын ил тод , хүртээмжтэй мэдээ, мэдээллийн тогтолцооны тухай" үндэсний оролцогч талуудын цахим хурлыг Байгаль орчны ба хөгжлийн "ЖАСЫЛ" Холбооноос НЭС хөтөлбөр ба ТАБХ -ийн хүрээнд 2020 оны 4 дүгээр сар 10-нд зохион байгуулав. Тус хуралд оролцогчид газар ашиглалт, үүний дотор бэлчээрийн газар ашиглалтын талаархи мэдээ, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын үр дүнгийн талаар дараахь илтгэл, танилцуулга хийж хэлэлцүүлэв. Үүнд:

- "Кадастрын нэгдсэн систем , Ланд Менежер программ" - Х. Оюунбаяр , ГЗБГЗЗГ, Кадастрын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- "Бэлчээрийн мэдээ, мэдээлийг сайжруулах төсөл"- Н.Ганхуяг, МБАНХ, гүйцэтгэх захирал
- "Монголын шар шороон шуурганы мэдээлэл, цаг агаарын аюулт үзэгдлээс учрах хохирол, урьдчилан сэрэмжлүүлэх"- Ж.Цогт, судлаач
- "Зах зээл, Бэлчээрийн удирдлагын төсөл", Т.Цэдэндамба , ХААХОУС/IFAD-ын төсөл
- "Бэлчээрийн сэргэх чадвахад суурилсан мониторингийн систем"- Д.Бурмаа, Монголы"н бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, "Ногоон алт –Малын эрүүл мэнд" төсөл
- "Монгол улсын Бэлчээрийн экосистемүүд: зохистой ашиглах, хамгаалах "-Ц.Мөнхнасан ,ХХААХҮЯ , МАА-ын Бодлого, зохицуулалтын газар
- "Монгол улсын Ойн сан"- Д.Жагдаг, БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газар
- "Газрын доройтлыг тэглэх үндэсний зорилт"- Н. Мандах ,Газарзүй, геоэкологийн Хүрээлэн
- "Байгаль орчин, газар ашиглалтын үндэсний статистик мэдээ, мэдээллийн тогтолцоо"- Ю.Батзоригт, ҮСХ-ны ҮТШСГ-ын статистикч
- "Монгол улсад газрын засаглалын үнэлгээ хийх LANDEX"- С. Сайнбаяр, Л.Уранбилэг , МГЗБХ /ХААИС,
- "Ланд Матрих: ГА-ын томоохон төслүүд"- Х.Ыханбай , "ЖАСЫЛ" Холбоо,
- "NES MONGOLIA платформ: бэлчээрийн менежментийн чиглэлээр хэрэгжүүлж үйл ажиллагаа"- Д.Эрдэнэбаатар, Бодлого судлалын төв

Цахим хурлаас газар ашиглалт, үүний дотор бэлчээрийн газар ашиглалтын ил тод мэдээ мэдээллийн хүртээмжийг сайжруулахад үндэсний оролцогч талуудын хамтарч хэрэгжүүлэх зарим үйл ажиллагааны талаар дараах зөвлөмж гаргаж, цаашид энэхүү үйл ажиллагааг Олон улсын бэлчээр ба нүүдэлийн малчдын жилийг зарлуулах тухай Монгол улсын саналтай уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- Үндэсний оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдааг сайжаруулж, ажлын хэсэг байгуулан газрын асуудлаар уулзалт, зөвлөлгөөн, хуралдааныг цаашид тогтмолжуулах
- Газар ашиглалтын одоо байгаа мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулж, арга зүйн хувьд ижилсүүлэн ГЗБГЗЗГ-ын Ланд Менежер программтай уялдуулах
- Бэлчээрийн мал аж ахуй, бэлчээрийн үнэлгээний тухай ойлголтыг өргөжүүлж, үүнийг ҮСХ-т хэрэгжиж эхэлсэн Байгаль орчин, эдийн засгийн дансны системтэй уялдуулах
- Холбогдох байгууллага ,төсөл хөтөлбөрүүдийн бэлчээрийн, тэр дундаа БАХ болон бусад бүтэц, зохион байгууллалтын талаархи мэдээ, мэдээллийг нэгтгэх, давхардал, орхигдолыг арилгах болон бодлого боловсруулагчид дэмжлэг үзүүлэх сайн туршлагын платформыг бий болгох замаар туршлага судлах боломжийг нээх
- Газар ашиглалт, үүний дотор бэлчээрийн газар ашиглалтын талаархи мэдээ, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг сайжируулах, сум орон нутаг, бэлчээр ашиглах малчдын бүлэг, хэсэг, холбоодын оролцоог бэлчээр, МАА-ын тухай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахад нэмэгдүүлж, ХХААХҮЯ болон оролцогч талууд энэ чиглэлээр улсын хэмжээний хурал зөвлөгөөний хөтөлбөрт тусгуулан мэдээлэл танилцуулга хийх, үндэсний түвшинд болон бүсчилсэн зөвлөгөөнийг хамтран зохион байгуулах
- Цаашид газар ашиглалтын бусад хэлбэрүүд болон газрын бусад ангилалд , тухайлбал хүлэр бүхий намархаг газарт гарч буй өөрчлөлт, түүнд тавих хяналт, холбогдох бодлогын орхигдлыг энэ снаачлагын хүрээнд уялдуулах
- БОАЖЯ ойн экологи эдийн засгийн үнэлгээний арга зүй, тоо хэмжээг ил тод болгож, холбогдох оролцогч талууд газар ашиглалтын эдийн засаг зэрэг судалгааны шинэ чиглэлүүдийг анхааралд авч, цаашид газарт учирсан хохирол, татвар болон бусад хураамж, төлбөрийн тооцоололд шинжлэх ухаанч арга барилыг хэвшүүлэх талаар хамтран ажиллах.





*Хуралдааны үеэр.Фото зургийг авсан И.Еркин, "ЖАСЫЛ"*
*Илтгэл, мэдээлэлийг хавсаргав*

## МАЛ АЖ АХУЙН САЛБАР ДАХЬ УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ЦААШДЫН ЗОРИЛТ

*Д.Батмөнх.(Ph D)., Ц.Мөнхнасан (Ph D)., Н.Бямбадорж*
*ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар*

ОРШИЛ

Мал аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 10.6 хувь, экспортын орлогын 8.4 хувийг бүрдүүлж нийт хүн амын гуравны нэгийг шууд, гуравны хоёрыг шууд бус байдлаар ажлын байраар хангаж байна. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл жилээс жилд өсч, 2018 онд 3.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 5.9 хувиар нэмэгдсэн. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт 2018 онд 580.0 сая ам.долларт хүрч өмнөх оны экспортоос 263.5 сая ам.доллараар буюу 1.8 дахин өссөн дүнтэй байна.

Мал аж ахуйн салбарт өсөлт бий болж байгаа ч Монгол орны уур амьсгалын бодит өөрчлөлт, байгалийн нөөцийн хүрэлцээ буюу бэлчээрийн доройтол, усны нөөцийн ашиглалт, хомсдлын асуудлыг Мал аж ахуйн салбарын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын асуудалтай нягт уялдуулан авч үзэх зайлшгүй шаардлага бий болсныг дор дурдсан үндэслэлүүдээр тодорхойлж байна.

### УУР АМЬСГАЛЫН БОЛОН БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Манай орны мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлого, хэрэгжилтийн үр дүнд цаг агаарын дулаарал болон байгалийн дараах хүчин зүйл хамгийн их нөлөөтэй, хөгжлийг хязгаарладаг гэж үзэхээр байна. Тухайлбал: Агаарын хэм дулаарсан, малын тоо өсөж, сүргийн бүтэц алдагдаж малын чанар муудсан, бэлчээрийн даац хэтэрсэн, мал аж ахуйг усаар хангах боломж хязгаарлагдмал, улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний аймаг, сумын отрын бүс нутгийн ашиглалт бага, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажлын цар хүрээ харьцангуй бага, эдийн засагт хохиролтой малын гоц халдварт өвчний гаралт нэмэгдэж байгаа зэргийг дурдаж байна.

### МОНГОЛ ОРНЫ ЦАГ АГААРЫН ДУЛААРАЛ

Монгол орны агаарын хэм 75 жилийн (1940-2015) хугацаанд 2.24о С хэмээр дулаарсан (Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн., 2016), жилийн турш орох хур тунадасны хэмжээ, хуваарилалт өөрчлөгдсөн, түүнчлэн говийн бүс нутагт уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэн нь хөдөөгийн хүн ам, мал сүрэг, газар тариалангийн усны хангамжид таагүй байдал үүсгэх болсон.

Манай орны хувьд гадаргын болон газар доорх усны нөхөн сэлбэгдэх нөөцийг бүрдүүлдэг хур тунадасны хэмжээ нь харьцангуй бага, орон зайн хувьд жигд бус тархсан, хур тунадастай байх хугацаа 3 сар бол усны ууршилт 7 сарын хугацаанд (усны толио гадарга болон ургамлан бүрхэвчээс) явагдаж байна. Онцолж хэлбэл, манай орны нутаг дэвсгэр, ялангуяа говийн бүс нутаг нь байгалийн аясаараа хуурайших үзэгдэлд нэрвэгдэж байдаг онцлогтой. Тухайлбал Орхон аймгийн Эрдэнэт УБҮ-ийн хаягдлын нуур, Эрдэнэт голын мандлаас жилд 673.84 мм хэмжээтэй ус (4,5,6,7,8,9,10 дугаар сар) ууршдаг бол Дорноговь аймгийн Сайншанд суманд энэ үзүүлэлт 1658 мм байдаг нь говийн бүс нутагт хангайн бүс нутгаас 2.4 дахин их ус усны толио гадарга болон ургамлан бүрхэвчээс ууршиж байгааг харуулж байна. Өмнөговь аймгийн Ханбогд суман дахь усны ууршилт 2000 мм-ээс дээш байдаг. (Д.Батмөнх., 2016 он).

Уур амьсгалын загварчлалаар агаарын хэм цаашид нэмэгдэх төлөвтэй ба манай орны нийт нутаг дэвсгэрийн 80-90 хувь нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөх өндөр магадлалтай гэж тодорхойлсон [6].

### МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, СҮРГИЙН БҮТЦЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Манай улс мал тооллогын ажлыг 1961 оноос эхлэн жил бүрийн эцэст явуулж ирсэн, тухайлбал 1961-ээс 1990 он хүртэлх 30 жилийн хугацаанд мал сүргийн тоо дунджаар 23.1 сая толгой, хонин толгойд шилжүүлснээр 49.5 сая толгой байсан. Зах зээлийн эдийн засагт шилжиж, малыг хувьчилснаас хойш малын тоо толгой тогтвортой өсөж, өнгөрсөн 58 жилийн хугацаанд буюу 2018 оны байдлаар 66.5 сая толгойд хүрч өссөн. Малын тоо 1961 онтой харьцуулахад 3.2 дахин буюу 45.8 сая толгойгоор нэмэгдсэн ба гол төлөв бог малын тоо ялангуяа ямааны тоо их өссөн үзүүлэлттэй байна [8].

Нийт малын тоонд 1961-1990 оны дунджаар ямаан сүрэг 19.5 хувийг эзэлдэг байсан бол 2018 онд 40.8 хувийг эзлэх болж сүргийн бүтэцэд томоохон өөрчлөлт гарчээ. Бог малын дотор хонь, ямааны эзлэх хэмжээ 1961-1990 оны дунджаар 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаатай байсан бол 2018 онд үндсэндээ 1 хонь, 1 ямаа гэсэн харьцаатай болж өөрчлөгдсөн байна [8].

Мал тооллогын дүнгээр 2018 оны жилийн эцэст манай улсын мал сүргийн нийт дүн 66 сая 460.2 мянган толгойд хүрч, 2017 оныхоос 0.4 хувь буюу 244.7 мянгаар өслөө. 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр адуун сүргийн тоо толгой 3 сая 940.1 мянга, үхэр 4 сая 380.8 мянга, тэмээ 459.7 мянга, хонь 30 сая 554.8 мянга, ямаа 27 сая 124 мянгад хүрч, 2017 оныхоос тэмээ 25.6 мянга, хонь 443.6 мянган толгойгоор өсөж, адуу 48 толгой, үхэр 7.8 мянга, ямаа 216.7 мянган толгойгоор тус тус буурчээ. Нийт мал сүргийн дотор адуу 5.9 хувь, үхэр 6.6 хувь, тэмээ 0.7 хувь, хонь 46 хувь, ямаа 40.8 хувийг тус тус эзэлж байна.

Малын тоо жил бүр тасралтгүй өсөж байсангүй байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр зарим жилүүдэд буурч эдийн засгийн хувьд хохирол учруулсан тохиолдлууд байлаа. Манай оронд сүүлийн 70 жилийн хугацаанд 12 удаагийн томоохон зуд тохиолдож байсан ба одоо байгаа бүх малын 60.3 хувьтай тэнцэхүйц хэмжээний малыг хорогдуулан мал аж ахуйн салбарт үлэмж хохирол учруулсан байна. Сүүлийн 70 жилийн хугацаанд Монголд тохиолдсон томоохон зуд, түүний үр дагаварыг нэгдүгээр хүснэгтэд харуулав.

### БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙН ХОМСДОЛ

Манай оронд байгалийн бэлчээр, хадлан нь бэлчээрийн малын тэжээлийн үндсэн эх үүсвэр байсаар байна. Нийт бэлчээрийн талбай 2017 оны эцэст 112.7 сая га болж багассан, энэхүү бэлчээрийн талбайн хэмжээг 1961 оны бэлчээрийн 140.0 сая га талбайтай харьцуулж үзвэл 19.9 хувиар буюу 27.9 сая га-гаар буурчээ. Мөн түүнчлэн бэлчээрийн талбайн тавны нэг нь уул уурхай, хот суурин зэрэг суурьшлын болон бусад салбарт шилжсэн байна. Ингэснээр 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1961 онд 32 байсан бол 2017 онд 99 болж, бэлчээрт үзүүлэх ачаалал 3.1 дахин нэмэгджээ [8].

Бэлчээрийн талбай нь 1964 оныхоос 7.7 хувь буюу 9.4 сая га-гаар буурсны дээр Монгол улсын нийт бэлчээрийн 22.6 хувь буюу 25.5 сая га бэлчээр ямар нэг хэмжээгээр доройтсны 10.3 сая га (35.8 хувь ) нь бага зэрэг, 12.6 сая га нь (49.5 хувь) дунд зэрэг, 3.7 сая га (14.6 хувь ) нь хүчтэй доройтсон тухай судалгааны дүн гарчээ. Үүнээс үзэхэд бэлчээрийн талбай буурахын зэрэгцээгээр манай улсын нийт бэлчээрийн бараг дөрөвний нэг нь доройтсон нь малын тэжээлийн байгалийн нөөцийг бууруулж, цаашид мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хязгаарлах хамгийн том хүчин зүйл болоод байна.

Мөн түүнчлэн цөлжсөн гэсэн ангилалд буй газрын ихэнх нь доройтсон бэлчээрт хамаарагдах ба энэ нь шороон шуурганы эх үүсвэр болж, Зүүн хойд Азийн бүсийн улс орнуудын байгаль орчин, цаашилбал эдийн засагт нь хохирол учруулах хэмжээнд хүрч болзошгүй байна. Гэтэл байгалийн бэлчээр нь зөвхөн малын тэжээлийн эх үүсвэр төдийгүй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хамгаас чухал үүрэг гүйцэтгэдэг.

ХААИС-ийн Экосистемийн төвийн судлаач Ж.Ундармаа (2015 он) доройтсон бэлчээрийн нөхөн сэргэх байгалийн чадавхи, өөрчлөлтийн судалгааг 2004 оноос эхлэн хийж байна. Тухайлбал нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг эзлэн тархсан уулын хээрийн дэд бүслүүр, хээрийн бүс, цөлийн хээрийн бүс болон цайдамд хамгийн өргөн уудам талбайд тархсан 4 төрлийн бэлчээрийн доройтлын судалгааг 15 жилийн хугацаанд хийж дараах дүгнэлтэд хүрээд байна. Үүнд:

1. Бага зэрэг доройтсон бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг хүчтэй доройтсон бэлчээртэй харьцуулахад хүчтэй доройтсон бэлчээрт нийт ургамлын зүйлийн 43.3-90 хувь нь мөхсөн байдаг. Тухайлбал, уулын хээрийн дэд бүслүүрт нийт зүйлийн 57.1 хувь нь, хээрийн бүсэд 43.2 хувь нь, цөлийн хээрийн бүсэд 90 хувь нь мөхдөг.
2. Бэлчээр хүчтэй доройтоход малд идэгддэг ургамлын зүйлийн тоо уулын хээрт 1.3 дахин, хээрт 1.4, цөлийн хээрт 1.8 дахин цөөрдөг.
3. Бэлчээр хүчтэй доройтсноор малд идэгдэх ургацын хэмжээ хээрт 2.4, цөлийн хээрт 1.3 дахин буурдаг. Харин уулын хээрт ургацын хэмжээ буурдаггүй боловч малд сайн идэгддэг үетэн ургамлын ургацын хэмжээ 72 дахин буурч, мал иддэггүй шарилжийн төрлийн ургамлын ургац 12 дахин нэмэгддэг. Бэлчээрийн малд идэгдэх бодит ургац буурснаар бэлчээрийн даац буурч байна.
4. Уулын хээр, хээр, цөлийн хээрийн бүс болон цайдмын доройтсон бэлчээрийг малын хөлөөс 15 жил (2004-2018) чөлөөлөн хашиж хамгаалахад хүчтэй болон дунд зэрэг доройтсон бэлчээр байгалийн аясаар сэргэхгүй байгаа нь тогтоогдсон байна.

### ДҮГНЭЛТ

1. Монгол орны агаарын хэм дэлхийн дундажаас ихээр нэмэгдсэн нь ууршилтыг ихэсгэж бэлчээрийн бүтээмжийг бууруулж байна.
2. Мал аж ахуйн болон бэлчээр ашиглалтын өнөөгийн тогтолцоо нь экологи, эдийн засгийн хувьд тогтвортой бус гэж олон улсын болон дотоодын эрдэмтэд дүгнэж байна.
4. Манай орны гадаргын болон газрын доорхи усны тархалт, нөөц, нөөцийн ашиглалтын менежмент нь хөдөөгийн хүн амын, мал аж ахуйн жилийн дөрвөн улирлын хэрэгцээг хангах хэмжээнд найдвартай усны эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй байна. .
5. Өнөөгийн байдлаар нийт мал сүргийн ердөө 1.0 хүрэхгүй хувийг Аймаг дундын отрын бүс нутагт өвөлжүүлж, хаваржуулах боломж бүрдсэн нь “нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч цаг хүндэрсэн үед ашиглах” арга хэмжээ хэрэгжээгүй байна.
6. Монгол орны бэлчээрийн ургамалд хөнөөл учруулагч мэрэгч амьтан, шавжны тархалт, хөнөөл нь малын тэжээлийн үндсэн эх үүсвэрийг туйлын эмзэг байдалд оруулж байна.

### ЦААШДЫН ЗОРИЛТ

1. Бэлчээрийн тухай хуулийн төсөлд Байгалийн бэлчээр, ус, малын тоо толгой зүй зохистой харьцааг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, үнэлэх, ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааны зохицуулалтыг оруулж, хуулийн төслийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх ажлыг эхлүүлж, зохион байгуулах,
2. Малын үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж малын үүлдэрлэг байдлыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж чанарыг сайжруулах, монгол малын тэсвэрт чанарыг бататгах, өндөр арвин ашиг шимт мал, амьтны тоог бодлогоор дэмжих зэргээр бэлчээрийн даацад тохирсон тооны мал сүргийг өсгөн үржүүлэх,
3.Бэлчээр, тэжээл, усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах, менежментийн нэгдсэн системийг бий болгож, мал аж ахуйг уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай болгох арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх,
4.Бэлчээр дэх хадлангийн талбайг нэмэгдүүлэх, хамгаалах, усжуулах, тэжээлийн ургамал тариалах талбайг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд өргөн хүрээтэй зохион байгуулж, засгийн газраас өвс тэжээлийг хадгалах агуулах, саравчийг барих ажилд хөрөнгө оруулах арга хэмжээ авах,
5.Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах, бэлтгэх ажлыг үр дүнтэй, харилцан ашигтай зохион байгуулах “Мал аж ахуйн үйлчилгээ” үзүүлэх компаниудыг байгуулах ажлыг судлах (Худаг, уст цэгийг үр ашигтай ашиглах, байгаль дахь усны нөөцийг хуримтлуулах, нөөцлөх, бэлчээрийг хуваарьтай ашиглах, бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах, малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, хадлан тэжээл бэлтгэх, хонь хяргах, угааж ариутгах үйлчилгээний төвлөрсөн цэгүүдийг байгуулах, махны хөргүүр, агуулахтай мал нядалгааны цех байгуулах, мах сүүний үнээний ферм байгуулах),

## БЭЛЧЭЭР НУТАГ ДУУСАХЫН ЦАГТ ИХ НҮҮДЭЛ ХААШАА ЧИГЛЭХ ВЭ...

Өвөг дээдсээс өвлөн ирсэн эх сайхан нутагтаа эзэн нь болон мэндэлсэн монгол түмний түүх соёл, ёс заншил минь бидний дэлхийн улс орнуудаас ялгарах ДАРХЛАА гэж болно. Хэдэн зуун жилээр амьдрал ахуйдаа ашиглан, хүнсний хэрэгцээндээ зориулж өсгөн үржүүлж ирсэн таван хошуу малгүйгээр монгол хүнийг төсөөлөх аргагүй. Хэдийгээр өнөөдөр уламжлалт нүүдлийн мал аж ахуй, суурин амьдралын хэв маяг гэсэн хоёр өөр хэв шинжэй болж байгаа ч эртний түүхт нүүдэлчин монголчууд бид өлсөхийн зовлонг үзээгүй. Тэр ч утгаараа 3 сая гаруй монголчуудын хүнсний хэрэгцээг хангах гэж дөрвөн улирлын аясаар мал аж ахуйгаа эрхэлж, өв уламжлалаа хадгалж байгаа малчин түмнийг хүндэтгэх учиртай билээ. 1 сая 566 мянган км2 уудам нутагтай, нэг хүнд ногдох газар нутаг, малынхаа тоогоор дэлхийд тэргүүлдэг Монгол Улсын нийт газар нутгийн 88.2 хувь буюу 140.5 сая га-г байгалийн бэлчээр эзэлж, 2 сая га хадлангийн газартай хэмээн үзэж байсан цаг саяхан.

Гэвч өнөөдөр байгаль цаг уурын өөрчлөлт, хур тундасны хомсдол, бэлчээр нутгийн зохисгүй ашиглалт, малын тоо толгой нэмэгдэх, сүргийн бүтцийн харьцаа алдагдсан зэрэг нь цөлжилт, бэлчээрийн хомсдол үүсэхэд хүргэж байна. Нийт нутгаар бэлчээрийн даац хэтэрсэнээр малын хөлд идэгдсэн ургамлын гарц буурах, ашиг шимт төрөл зүйлийн тоо багасахын хирээр жилээс жилд отор нүүдэл хийх малчдын тоо нэмэгдсээр байна. Бэлчээр бол малчдын мал сүргээ өсгөн үржүүлэхэд чухал үүрэгтэй амьжиргааны гол эх үүсвэр. Гэтэл бэлчээрийг хайр гамгүй ашиглаж байгаа нь байгалийнхаа жамаар нөхөн сэргэх боломжийг олгохгүй байна. 2019-2020 оны өвөл, хавар 22 мянга гаруй өрхийн 10 сая гаруй мал отроор, 57.5 сая мал суурин өвөлжөө, хаваржаандаа байх тооцоо гарчээ. Өнөөдрийн байдлаар Архангай, Булган, Дундговь, Өвөрхангай, Төв аймгийн 3.2 сая мал Архангай, Булган, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Төв аймагт отор нүүдэл хийж байна. Зуншлага муу, гантай байсан аймгуудын малыг улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Чилэн, Хөх дэл, Малах, ХэрлэнбаянУлааны отрын бүс нутагт оруулжээ. 2019-2020 онд аймаг дундын отрын есөн бүс нутагт 11 аймаг, Улаанбаатар хотоос 600 орчим мянган толгой малыг өвөлжүүлж, хаваржуулахаар шийдвэрлэсэн. Малчид өвс, тэжээл, сүрэл, дарш, давс, хужрынхаа 90 гаруй хувийг бэлтгэсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргүүдийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн бэлтгэл 70 хувьтай байгааг гэдгийг салбарын яамнаас мэдээлсэн юм.

Малчид өвлийн хахир цагийг давж, урин хавартай золгохын тулд өөрийн чадах бүхий л аргаа хэрэглэдэг ч гэлээ зайлшгүй нөхцөлд отор нүүдэл хийхээс аргагүйд хүрдэг. Нутаг орноо орхиод өөр аймаг суманд “ОТРЫНХОН” гэсэн хэмээн ад үзэгдэх нь энүүхэнд. Гэхдээ л хэдэн малынхаа буянг хүртэж яваа бидэн шиг малчин хүн хэмээн тухайн сум орон нутгийнхан тэднийг хүлээн авч өвөлжүүлсээр ирсэн. Магадгүй тухайн сум орон нутагт бэлчээрийн даац нь хэтэрсэн байсан ч гэлээ сум орон нутгийн удирдлага, бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, Бэлчээр ашиглагч малчдын бүлэгтэйгээ ярилцаж хэлэлцээд отрынхон буух газрыг зааж өгдөг. Зарим тохиолдолд өөрийн өнжөөж амраасан газраа алдчихлаа хэмээн нутгийн малчид бухимдаж, отрынхонтой гар зөрүүлээд авдаг ч тохиолдол мэр сэр гардаг гэдэг. Монгол Улсын иргэн хаана ч амьдрах эрхтэй гэдэг утгаараа төрж, өссөн нутгаа орхиод малчин хүн малаа дагаад отор нүүдэл хийхийг буруутгах аргагүй ч одоо байгаа бэлчээрээ зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээж, хайрлан хамгаалах учиртай. Хэдийгээр малын хөлд талхлагдсан бэлчээрийг зөв менежменттэйгээр нөхөн сэргээхэд цаг хугацаа орно. Гэтэл талхлагдсан нутгаа орхиод өөр газар нүүснээр доройтсон бэлчээрийн цар хүрээ улам бүр нэмэгдсээр л байна.

Хоёр жилийн өмнөөс Сүхбаатар аймгийн зарим суманд хонь нь хулгана барьж идсэн тухай мэдээлэл гарч монголчуудыг цочирдуулж байв. Үнэхээр санаанд багтамгүй, сэтгэл зовоосон мэдээлэл боловч бэлчээрийн доройтолтой, хуурайшилттай, өвс тэжээлгүй болсноос хонь нь хулгана барьж идсэн болов уу. Дан ганц хонь гэлтгүй ямаа ч хулганаар хооллох үзэгдэл Хэнтий аймагт ч гарсан байдаг. Бэлчээрийн даац хэтэрч, байгалынхаараа сэргэх чадвар нь буурсан газар нутгийн хэмжээ улам бүр нэмэгдсээр байгааг энэхүү хонь, ямаа нь хулгана идсэн тохиолдлууд гэрчилнэ. Гэтэл сэргэх чадвар нь буурч, бэлчээрийн доройтолд орж буй аймаг сумдууд улам их нэмэгдсээр байна. Тухайлбал, Төв аймгийн Өндөрширээт суманд жилийн жилд отрынхон орж ирдэг, бэлчээрийн даац хэд дахин хэтэрсэн, цөлжилт нүүрлэж, төрсөн нутагтаа амьдрах аргагүй болох гээд байна. Одоогоос 3 жилийн өмнө Өндөрширээт сум 170 мянга гаруй толгой малтай байсан бол өнөөдөр 270 мянга гаруй толгой малтай болсон. Нэмээд 160 аад өрхийн 100 гаруй мянган мал отроор орж ирээд өвөлжиж байгаа. Отрынхон бага орж ирдэг байхад бэлчээрийн даац хэтэрсэн ч ургамлын ургац гайгүй байсан. Гэвч жил ирэх тусам малын тоо ихсээд, бэлчээр талхлагдан өвс ургамал нь багассаар нутагтаа үлдэж дасан зохицох уу, нутгаа орхиод отрынхонтой нэгдэх үү гэдэг асуудал яригдахад ойрхон байгааг нутгийнхан хэлж байна

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН УЯНГЫН III ДУГААР БАГИЙН МАЛЧИН М.БҮРЭНЗЭВСЭГ ХЭЛЭХДЭЭ:

“Өнөө жил цас багатай дулаахан сайхан өвөл болж байна. Манайх 1000 малтай, дийлэнх нь бог мал. Манай багт 70 гаруй өрх мал маллаж байна. Баг гэдэг хэдий хэмжээний газартай байх билээ. Дээр нь Дундговь аймгийн Эрдэнэдалай, Өвөрхангай аймгийн БаянӨндөр, Төв аймгийн Дэлгэрхаан сумаас эзэнгүй адуу их ирж байна. Өвс илт багасч, мал идэх юмгүй болох нь. Хаврын хавсрага болж, цаг агаар хэцүүдэхэд босоо юмгүй болох вий л гэж санаа зовж байна. Уг нь нутгийн малчид бид хоорондоо хэлэлцээд Бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулаад сум, орон нутгийнхаа хэмжээнд зохицоод бэлчээрээ өнжөөж амраадаг. Гэвч бэлчээрийн асуудлыг шийдэх хуулийн нарийн зохицуулалт байхгүй учраас гаднаас отор ороод ирэхэд буцаах эрх байдаггүй. Манай сумын хэмжээнд 8 хэсэг байдаг. Зөвхөн манай Мөөрс хэсэг гэхэд 53 өрхтэй. Бид зунжин зохицуулалт хийгээд өвлийн бэлчээрээ хамгаалж, бэлдээд ямар ч үр дүнгүй байна. Бэлчээрийн хууль хэрэгтэй. Хууль эрх зүйн зохицуулалт хийхдээ малчдын санал санаачлагыг үндэслэвэл амьдралд илүү ойрхон байх болно”

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН УЯНГЫН III ДУГААР БАГИЙН МАЛЧИН Г.ОТГОНСАЙХАН ХЭЛЭХДЭЭ:

“Энэ өвөл харьцангүй дулаахан сайхан л байлаа. Даанч отор нүүдэл орж ирээд мал идэх өвсгүй болчихлоо. Бидний зунжингаа бэлчээрээ хамгаалахын тулд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүн гарахааргүй л болчихлоо. Хаваржилт хэцүү л байх нь. Отрынхон яахав өвлийг даваад, хэдэн мал нь бэлчээр талхалчихаад яваад л өгнө. Зарим нь нүүхгүй үлдэх эсэхийг нь мэдэхгүй юм. Гэтэл бид нутгаа орхиод явахад тулаад байна. Манайх гэхэд эндээс 50 орчим км хол газар адуугаа оторт гаргалаа. Бог мал нь багахан хоолтой байгаад л байна. Одоо мал төллөөд эхлэхээр идэх өвсгүй болчихно. Отор нүүдэл хийх болох нь уу яахнав. Хаваржаанд уг нь айл буугаагүй ч бэлчээрийг нь отрын адуу эзэнгүй адуунууд дуусгачихсан. Эзэнгүй адуу ч гэж хаана байхав. Эзэн нь хаа нэгтэйгээс хараад байж байдаг байлгүй дээ. Үнэхээр бэлчээрийг хамгаалж, анхаарахгүй бол малчид бидний сум орон нутагтаа хийдэг зохицуулалтаар шийдэж барахгүй болж байна. Хууль эрх зүйн талаас нь анхаарч нэг чиглэлтэй болгох хэрэгтэй. Тэгж байж бэлчээрээ хамгаалж, зөв ашиглаж, үр хойчдоо хадгалж үлдээнэ”.

Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын хувьд бэлчээр маш чухал. Бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх нь зэрлэг амьтдад ч тустай. Тиймээс малын тоог хэт өсгөхгүй байх, бэлчээрийг хуваарьтай, зөв зохистой ашиглах, өнжөөж амраахын үнэ цэнийг малчид, төдийгүй энэ чиглэлд анхаарал хандуулдаг хүн бүхэн хэлж ярьж байна. Нөгөө талаар дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлт илүү ихээр мэдрэгдэх болсон энэ цаг үед Бэлчээрийн тухай хуулийн зохицуулалт хийж байж, ирээдүйд монгол малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлнэ. Учир нь бэлчээрийн доройтлоос үүдэн жилээс жилд малын ашиг шимийг нэмэгдүүлдэг шимт ургамалын тоо, төрөл цөөрч, дахин сэргэхээргүй болж байгааг эрдэмтэн судлаачид хэлж ярьсаар байна. Бэлчээрийн тухай хуулийг батлах асуудал нь хууль тогтоогчдын ярианы гол сэдэв байдаг ч гэлээ батлагдахгүй дуншсаар байгаа нь нууц биш. Гэтэл Киргиз улсын төлөөлөгчид 2008 онд манай улсад айлчилж, Бэлчээрийн тухай хуулийн төслийн зүйл заалтаас өөрийн улсдаа ашиглаж болох хэсгийг нь тэмдэглэж аван нутагтаа очоод Хууль баталчихсан байх юм.

Тэд 2018 онд манай улсад ирэхдээ Бэлчээрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж, 10 жилийн алдаа оноо, засаж сайжруулах асуудлуудаар санал солилцоод явсан. Харин бид Хууль ч үгүй явсаар л. Бэлчээрийн тухай хуультай боллоо гээд хэдэн малчдад монголынхоо газар нутгийг хуваагаад, хашаалаад өгчихнө гэсэн ойлголт биш. Харин хуулийн дагуу асуудлыг шийдэх боломж юм. Тухайлбал, тухайн жилийн байгаль цаг уурын нөхцөл ямар байснаас шалтгаалаад ургамлын гарц ямар байсан, бэлчээрийг хэрхэн зөв зохистой ашиглах, аль нэг аймаг суманд очиж отор нүүдэл хийлээ гэхэд бэлчээр ашигласаны төлбөрөө хэрхэн өгөх тухай асуудал юм. Уг төлбөрийг нь тухайн орон нутгийн бэлчээрийг нөхөн сэргээх, холын аяныг даван туулж чадаагүй орхиод явдаг малынх нь сэг зэмийг устгаж байгаль орчноо хамгаалах, халдварт өвчнөөс сэргийлэх зэрэг олон асуудлыг Хуулийн хүрээнд шийдэх зохицуулалт болж чадна. Магадгүй бид энэ асуудлаа шийдэхгүй явсаар байвал талхлагдсан газар нутгийг улам л их болж, малчдын бэлчээрээс үүдэлтэй маргааныг шийдвэрлэхэд улам л бэрх болно. Эцэст нь мал бэлчээрлэх газаргүй болчихвол отрынхоны их нүүдэл хаашаа чиглэх вэ...

Мал бэлчээрлэх газаргүй болчихвол монголчууд бид, үр хойч минь хэрхэн амьдрах вэ...

П.Нарандэлгэр

# CALLING FOR YOUR SUPPORT TO DESIGNATE AN INTERNATIONAL YEAR OF RANGELANDS & PASTORALISTS

The condition and productivity of the world's rangelands are critical to our sustainable future. Not only for people directly depending on these lands for their livelihoods but also for the billions more benefiting from them for tourism, wildlife and biodiversity, meat and milk and other agricultural products, mining, renewable energy and other uses. To increase knowledge and understanding about these unique ecosystems and the people who rely on them, we urge you to join the effort to gain a United Nations (UN) resolution designating an International Year of Rangelands & Pastoralists (IYRP).

Justification

